

БАТЛАВ  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА Ч.МӨНХТУЯА

2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ISO СТАНДАРТЫГ  
НЭВТРҮҮЛЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

<b>1. Зорилго</b>	Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагаанд "ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлж хэрэгжилтийг хангах.
<b>2. Ажлын үндэслэл</b>	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО"-ын I үе шат (2021-2030): Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх үе: "5.Төрийн үйлчилгээний чанарын стандарт бий болж, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшсөн байна." "Монгол улсын 2024 оны төсвийн тухай" хуулийн Монгол Улсын Шадар сайдын хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн: "17.3.1 Стандартчилал, тохирлын найдвартай байдлыг хангана. 17.3.1.4 Чанарын удирдлагын тогтолцооны баталгаажуулалтад хамруулах байгууллага, аж ахуйн нэгжийн тоо-162" Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр баталсан "Иргэний нисэхийн ерөнхий газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний 12.8 дахь заалтыг тус тус үндэслэв.
<b>3. Ажлын хамрах хүрээ</b>	Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод бүтэц зохион байгуулалтын хэмжээнд 100 хүртэл ажиллагсад бүхий (Аюулгүй ажиллагааны дотоод хяналт, дүрмийн боловсруулалтын алба, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын алба, Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, Захиргаа удирдлага, хууль, эрх зүйн хэлтэс, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс, Гадаад хамтын ажиллагааны хэлтэс) нэгжүүдийн үйл ажиллагаа;
<b>4. Гүйцэтгэх ажлын үе шат, ажлын бүрдэл</b>	<b>Ерөнхий ажил, үйлчилгээ</b> 1.Стандартын модуль сургалт зохион байгуулах; 2.Ажлын байран дахь уулзалт семинар болон цахим уулзалтыг зохион байгуулах; 3.Стандарт нэвтрүүлэх чиглэлээр байгууллагын төлөв байдлын болон зөрүүгийн шинжилгээ хийх; 4.Стандарт нэвтрүүлэх шат дараалалтай арга зүйн зөвлөгөөг өгөх, баримтжуулсан мэдээлэл боловсруулахад дэмжлэг үзүүлэх; 5.Дотоод аудит болон удирдлагын дүн шинжилгээ хийхэд аргазүйн зөвлөгөө өгч хамтарч ажиллах; 6.Хөндлөнгийн аудит, баталгаажуулалт хийлгэхэд Стандартчилал, Техникийн зохицуулалт, Тохирлын Үнэлгээний Итгэмжлэлийн тухай хуулийн дагуу хөндлөнгийн аудит, баталгаажуулалт хийлгэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх.  <b>А. Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын дагуу хэрэгжилт, үйл явцын эхний үе шат</b> 1.Байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн төлөв байдал /Гадаад, дотоод хүчин зүйлс, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, байгууллагын давуу ба сул тал/-ыг тодорхойлох; 2. Зөрүүгийн /GAP/ шинжилгээ хийх, шинжилгээгээр дүгнэлт гаргаж үйл явцуудыг тодорхойлох, баримтжуулсан мэдээллийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах;

	<p>3. Удирдлагууд болон нийт ажилтнуудад танилцуулах сургалт зохион байгуулах;</p> <p>4. Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гаргах, батлуулах.</p> <p><b>Б. Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын дагуу ажилтнуудыг дэмжих үйл явцын үе шат</b></p> <p>5. GAP шинжилгээгээр илэрсэн орхигдсон үндсэн ба туслах процессуудын зураглалыг тодорхойлж, холбогдох баримт бичиг, журам, маягтуудыг боловсруулах;</p> <p>6. Стандартын мэдлэг олгох шаталсан сургалтууд, стандарт нэвтрүүлсэн байгууллага /дотоод, гадаад/-ын туршлага судлах үйл ажиллагааг зохион байгуулах.</p> <p><b>В. Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын дагуу хэрэгжүүлэх үе шат</b></p> <p>7. Стандарт нэвтрүүлэхтэй холбоотой төлөвлөлтийг боловсруулж, батлуулан хэрэгжүүлж, хянахад ажилтнуудын оролцоог хангах, хамтран ажиллах;</p> <p>8. Стандартыг нэвтрүүлэх үе шатны сургалтыг зохион байгуулж, дотоод хүний нөөцийг бэлдэх;</p> <p>9. Зөвлөмж, зааврыг гаргаж, хэвлэмэл материал, зааварчилгааг тараан байршуулж, үйл ажиллагааны түвшин бүрд бүртгэл бий болгох;</p> <p><b>Г. Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын дагуу гүйцэтгэлийг үнэлэх, сайжруулах үе шат</b></p> <p>10. Стандартын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, дотоод аудит хийх ажилтнуудыг сургах, аудит хийхэд дэмжлэг үзүүлэх, сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;</p> <p>11. Удирдлагын дүн шинжилгээг хийх.</p>
<p><b>5. Тавигдах шаардлага</b></p>	<p>1. Гүйцэтгэгч нь менежментийн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, Удирдлагын тогтолцооны олон улсын стандарт нэвтрүүлэхэд зөвлөгөө өгөх эрхтэй байх;</p> <p>2. Чанарын менежментийн тогтолцооны сургалт, зөвлөхийн ажил гүйцэтгэх үр чадварыг эзэмшсэн, ISO стандарт, менежментийн бусад арга хэрэгслүүдээр мэргэшсэн, мэргэжлийн өндөр түвшний сургалт, зөвлөгөө өгөх туршлага, авьяас, чадвартай мэргэжилтнүүдээр багаа бүрдүүлсэн байх;</p> <p>3. ISO 9001:2015 стандарт болон менежментийн бусад арга хэрэгслээр мэргэшсэн, тус стандартыг 500 буюу түүнээс дээш ажилтантай төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад хэрэгжүүлсэн байх;</p> <p>4. Үндсэн зөвлөхүүд болон хамтран ажиллах зөвлөхүүдийн намтар, ажлын туршлагын мэдээлэл;</p> <p>5. Өмнө хийж гүйцэтгэж байсан ижил төстэй ажлын туршлага /төрийн байгууллагын үйл ажиллагаанд олон улсын чанарын менежментийн тогтолцооны стандарт нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээг 3-аас доошгүй байгууллагад хийж гүйцэтгэсэн тодорхойлолт/.</p> <p>6. Бусад шаардлага:</p> <p>5.1. GAP шинжилгээ, чанарын болон тоон судалгааны боловсруулалт хийдэг программ хангамж, судалгаа явуулах арга аргачлал, мэдээллийн баазтай байх;</p> <p>5.2. Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөртэй байх, сургалтад ашиглагддаг сүүлийн үеийн заах арга зүй, арга хэрэгслүүдтэй байх;</p> <p>5.3. Сургалт, зөвлөгөөний тараах материал, мэдээллийн хуудас, ном, гарын авлагаар хангах боломжтой байх;</p> <p>5.4. Чанарын менежментийн тогтолцоог байгууллагад нэвтрүүлсний дараа сайжруулалт хийх, байгууллагад дэмжлэг үзүүлэх чадвартай, нөөцтэй байх;</p> <p>5.5. Дор дурдсан чадвар бүхий гишүүдээс бүрдсэн баг бүрдүүлсэн байна. Үүнд:</p> <p>a/. Менежментийн чиглэлээр мэргэшсэн, зөвлөх, удирдах ажил хийсэн 5 болон түүнээс дээш жилийн туршлагатай байх;</p> <p>b/. Төрийн байгууллага (яам, агентлаг)-д чанарын удирдлагын менежментийн чиглэлээр техникийн туслалцаа үзүүлж байсан туршлагатай байх, туршлагаа нотлох;</p>

	<p>в/. Төслийн менежментийн туршлагатай байх, үүнд чанарын менежментийн төслийг удирдан, 500-аас дээш ажилтантай 3-аас доошгүй байгууллагад амжилттай хэрэгжүүлсэн байх;</p> <p>г/. Холбогдох талуудын ажлын уялдааг хангах, мэдээллээр хангах, хамтран ажиллах харилцааны удирдах ур чадвартай, асуудал шийдвэрлэх чадвар эзэмшсэн байх;</p> <p>д/. Асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, асуудалд дүн шинжилгээ хийх өндөр ур чадвартай, бодлого боловсруулах түвшинд ажиллаж байсан туршлагатай байх;</p> <p>е/. Англи хэлний ярианы болон бичгийн, харилцааны өндөр чадвартай байх;</p> <p>ж/. Тайлагнах, бусдад ойлгуулах, илтгэх, харилцааны өндөр чадвартай байх;</p> <p>з/. Байгууллагын нууцыг хадгалах, ёс зүйтэй, найдвартай байх.</p>
<b>6. Ажлын тайлан, хяналт</b>	<p>1. Зөвлөх үйлчилгээг үзүүлэх байгууллага нь холбогдох бүх шатны мэдээлэл, улирал бүрийн ажлын явцын тайлан, нэгдсэн тайлан болон бусад холбогдох материалыг ажил дуусахад захиалагч талд албан ёсоор хүлээлгэн өгнө.</p> <p>2. Нэгдсэн тайлан, зөвлөмж, санал дүгнэлт, мэдээлэл, холбогдох материалыг 3 хувь үйлдэж цаасаар болон цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>3. Тайлан, зөвлөмжийн баримт бичиг нь Захиалагчийн өмч болох ба түүний зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.</p>
<b>7. Ажил гүйцэтгэх хугацаа</b>	<p>1. Төслийг хэрэгжүүлэгч нь захиалагч байгууллагатай ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлж, бүрдүүлэхэд 1 жилийн хугацаанд хамтран ажиллана.</p> <p>2. Ажил гүйцэтгэх гэрээнд захиалагчтай зөвшилцсөнөөр хугацааг нарийвчлан тусгаж, гэрээнд заасны дагуу ажлыг эхлүүлнэ.</p> <p>3. Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх арга аргачлал, ажлын хэмжээ болон хуанлийн нарийвчилсан төлөвлөгөөг урьдчилсан байдлаар бэлтгэж захиалагчид танилцуулан батлуулна.</p>
<b>8. Бусад</b>	<p>1. Байгууллагын танилцуулга;</p> <p>2. Нийгмийн даатгалын газар, харилцагч банкны тодорхойлолт;</p> <p>3. Тендерт оролцогч хуулийн этгээд нь сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаа, гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой асуудлаар шүүхэд хариуцагчаар оролцож байсан эсэх талаарх лавлагаа;</p> <p>4. Сүүлийн 2 жил буюу 2022, 2023 оны санхүүгийн хураангуй тайлан, аудитын дүгнэлт;</p> <p>5. Татварын цахим тодорхойлолт (татварын өргүй байх ба ажил гүйцэтгэх санхүүгийн чадамж);</p> <p>6. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх баг нь 3-аас доошгүй гишүүдээс бүрдсэн байна;</p> <p>7. Ажлын багтаамж, удирдамжид захиалагч болон гүйцэтгэгч талуудын зөвшилцлийн үндсэн дээр ажлын хамрах хүрээ зорилгод өөрчлөлт оруулж болно.</p>

ХЯНАСАН:

ЗАХИРГАА УДИРДЛАГА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН  
ГҮЙЦЭТГЭГЧ, САНХҮҮ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Д.ХАТАНБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА УДИРДЛАГА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ЗАХИРГААНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Ц.БАТЧИМЭГ